ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Завхан аймгийн Отгонтэнгэр рашаан сувилалын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2024/05/НА-СТА-ТШЗ

---


Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Оюунсувд

Утас: 99076038

Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Гэрээт аудитор: Г.Уранбаяр

Утас: 95183025

Цахим хаяг: gonchigdorjuranbayr@gmail.com


Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2024 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга....8

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11

4. Аудитын тайлан....13

4.1 Ерөнхий зүйл ....13

4.2 Материаллаг байдал ....14

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт....14

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....14

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....16

5. Аудитын илрүүлэлт ....16

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл
**16**


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.23 № 139

танай ____________ -ны № ____________ -т

ЗАВХАН АЙМГИЙН ОТГОНТЭНГЭР
РАШААН СУВИЛЛЫН ДАРГА
Д.ЦОЛМОН-Д

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан аймгийн Отгонтэнгэр рашаан сувиллын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан аймгийн Отгонтэнгэр рашаан сувиллын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Завхан аймгийн Отгонтэнгэр рашаан сувилал нь эрүүл мэндийн даатгалын сангаас 299.5 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагаанаас 2.5 сая нийт 302.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэн зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Завхан аймгийн Отгонтэнгэр рашаан сувилал нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар зөрчил илрээгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулаагүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

01-0-0030

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**2023 оны 12 дугаар сарын 31** **/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **53,553,824.09** | **44,103,289.04** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 0.01 | |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0.01 | |
| 33 | **АВЛАГА** | 10,256.04 | 10,256.04 |
| 33100 | Хувь хүмүүсээс авах авлага | 10,256.04 | 10,256.04 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 200,000.00 | |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 200,000.00 | |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | **53,343,568.04** | **44,093,033.00** |
| 351 | **Түүхий эд материал** | 20,837,633.02 | 17,729,735.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 18,870,948.02 | 16,475,300.00 |
| 35130 | Эм боох материал | 1,966,685.00 | 1,254,435.00 |
| 354 | **Хангамжийн материал** | 32,505,935.02 | 26,363,298 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 470,900.00 | 320,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 21,210,100.00 | 18,450,000.00 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 1,700,000.02 | 5,400,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 7,233,000.00 | |
| 35460 | Хүнсний материал | 1,659,935.00 | 1,538,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 232,000.00 | 654,798.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 103,108,046.25 | 90,615,158.75 |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 103,108,046.25 | 90,615,158.75 |
| 392 | **Биет хөрөнгө** | 33,666,046.25 | 21,173,158.75 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 112,599,600 | 112,599,600 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -111,599,601 | -112,266,267.72 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 39,041,639.48 | 39,041,639.48 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -25,795,574.12 | -29,044,732.05 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 50,891,379.96 | 50,891,379.96 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -31,630,517.57 | -40,207,580.42 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 9,816,000.00 | 9,816,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -9,816,000.00 | -9,816,000.00 |
| 39217 | Ном | 159,119.50 | 159,119.50 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 69,442,000.00 | 69,442,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 69,442,000.00 | 69,442,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **156,661,870.34** | **134,718,447.79** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **36,840,557.48** | **24,622,769.82** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 36,840,557.48 | 24,622,769.82 |
| 413 | Өглөг | 36,840,557.48 | 24,622,769.82 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 26,851,997.48 | 24,622,769.82 |
| 413213 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 3,379,310.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| **41330** | Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | 3,074,500.00 | |
| **41361** | Бусад өглөг | 3,534,750.00 | |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **119,821,312.86** | **110,095,677.97** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 119,821,312.86 | 110,095,677.97 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 211,301,260.12 | 211,301,260.12 |
| 51101 | Өмч: - төрийн | 211,301,260.12 | 211,301,260.12 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -92,514,918.37 | -102,240,553.26 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -52,912,131.11 | -92,514,918.37 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -39,602,787.26 | -9,725,634.89 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,034,971.11 | 1,034,971.11 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **156,661,870.34** | **134,718,447.79** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **416,822,386.02** | **302,111,300** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **129,543,960.02** | **2,573,000.00** |
| **120** | Нийтлэг татварын бус орлого | 129,543,960.02 | 2,573,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 128,216,214.02 | 2,573,000.00 |
| | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 114,586,500.02 | |
| | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,629,714.00 | 2,573,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,327,746.00 | |
| 122 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 287,278,426.00 | 299,538,300.00 |
| **134001** | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 287,278,426.00 | 299,538,300.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 287,278,426.00 | 299,538,300.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 456,425,173.28 | 311,836,934.89 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 456,425,173.28 | 311,836,934.89 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 456,425,173.28 | 311,836,934.89 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 122,206,417 | 50,832,558.14 |
| 210101 | Үндсэн цалин | 25,001,414 | 32,063,423.29 |
| 210102 | Нэмэгдэл | 95,801,003 | 18,769,134.85 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,404,000 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 19,581,516.45 | 16,300,000 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,437,227.73 | 16,300,000 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,688,614.08 | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,089,592.26 | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 439,357.22 | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,926,725.16 | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,800,467.69 | 15,524,916.39 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,453,187.69 | 645,606.39 |
| 210302 | Түлш, халаалт | 7,290,000 | 7,500,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,057,280 | 3,379,310 |
| 210304 | Байрны түрээс | | 4,000,000 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,828,689.18 | 24,801,158.03 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,284,770 | 1,154,850 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,413,389.18 | 13,918,900 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 2,128,700 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 558,940 | 60,000 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 658,200 | 7,538,708.03 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,913,390 | |
| **2105** | **Нормативт зардал** | 75,203,579.8 | 90,337,847.5 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,481,784.5 | 27,886,764.5 |
| 210502 | Хоол, хүнс | 71,365,395.3 | 58,131,083 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,356,400 | 4,320,000 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 17,770,289.4 | 27,371,227.47 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 6,185,000 |
| 210604 | Урсгал засвар | 17,770,289.4 | 21,186,227.47 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 181,221,326.26 | 74,176,339.86 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 178,826,376.26 | 72,676,339.86 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 69,700 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 16,000 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 700,000 |
| 210807 | Газрын төлбөр | 1,733,250 | 800,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 16,812,887.5 | 12,492,887.5 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 16,812,887.5 | 12,492,887.5 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-39,602,787.26** | **-9,725,634.89** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-39,602,787.26** | **-9,725,634.89** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | **418,569,140.02** | **302,111,300.00** |
| **12** | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 131,290,714.02 | 2,573,000.00 |
| **120** | Нийтлэг татварын бус орлого | 131,290,714.02 | 2,573,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 131,290,714.02 | 2,573,000.00 |
| | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 114,586,500.02 | 2,573,000.00 |
| | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 16,704,214.00 | |
| | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 287,278,426 | 299,538,300.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 287,278,426 | 299,538,300.00 |
| **134002** | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 287,278,426 | 299,538,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **409,659,140.01** | **302,111,300.01** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **409,659,140.01** | **302,111,300.01** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **409,659,140.01** | **302,111,300.01** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 108,097,731.35 | 50,832,558.15 |
| 210101 | Үндсэн цалин | 11,415,004 | 32,063,423.29 |
| 210102 | Нэмэгдэл | 96,682,727.35 | 18,769,134.86 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 12,412,000 | 16,300,000 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,440,000 | 16,300,000 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 993,000 | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 794,000 | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 199,000 | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,986,000 | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 5,481,157.69 | 15,524,916.39 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,453,187.69 | 645,606.39 |
| 210302 | Түлш, халаалт | 3,350,000 | 7,500,000 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 677,970 | 3,379,310 |
| 210304 | Байрны түрээс | | 4,000,000 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,986,900 | 18,847,250 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,125,870 | 1,135,950 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,361,790 | 13,918,900 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 558,940 | 2,128,700 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 425,100 | 60,000 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,515,200 | 1,603,700 |
| **2105** | **Нормативт зардал** | 96,448,960 | 90,491,248 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 7,572,810 | 28,162,100 |
| 210502 | Хоол, хүнс | 84,582,200 | 58,009,148 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,293,950 | 4,320,000 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 21,112,289.4 | 27,371,227.47 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 6,185,000 |
| 210604 | Урсгал засвар | 21,112,289.4 | 21,186,227.47 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 155,120,101.57 | 82,744,100 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 154,457,601.57 | 81,244,100 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 69,700 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16,800 | |
| 210807 | Газрын төлбөр | | 700,000 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **8,910,000.01** | **-0.01** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **8,910,000** | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **8,910,000** | |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 8,910,000 | |

| | | | |
|---|---|---|---|
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 8,910,000 | |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | -8,910,000 | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **211,301,260.12** | **1,034,971.11** | **-92,514,918.37** | 119,821,312.86 |
| D01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **211,301,260.12** | **1,034,971.11** | **-92,514,918.37** | 119,821,312.86 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **211,301,260.12** | **1,034,971.11** | **-92,514,918.37** | 119,821,312.86 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | -9,725,634.89 | -9,725,634.89 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **211,301,260.12** | **1,034,971.11** | **-102,240,553.26** | 110,095,677.97 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **302,111,300.01** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **302,111,300.01** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **302,111,300.01** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 50,832,558.15 |
| 210101 | Үндсэн цалин | | 32,063,423.29 |
| 210102 | Нэмэгдэл | | 18,769,134.86 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 16,300,000 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 16,300,000 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 15,524,916.39 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 645,606.39 |
| 210302 | Түлш, халаалт | | 7,500,000 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 3,379,310 |
| 210304 | Байрны түрээс | | 4,000,000 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 18,847,250 |
| 210401 | Бичиг хэрэг | | 1,135,950 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 13,918,900 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 2,128,700 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 60,000 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 1,603,700 |
| **2105** | **Нормативт зардал** | | 90,491,248 |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 28,162,100 |
| 210502 | Хоол, хүнс | | 58,009,148 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 4,320,000 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 27,371,227.47 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 6,185,000 |
| 210604 | Урсгал засвар | | 21,186,227.47 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 82,744,100 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 81,244,100 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 700,000 |
| 210807 | Газрын төлбөр | | 800,000 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **302,111,300** |
| **33** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | | **299,538,300** |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | | 299,538,300 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | | 16 |
| 620001 | Удирдах ажилтан | | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | | 12 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | | 3 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн Отгонтэнгэр рашаан сувилал нь Хүнлэг энэрэнгүй ёсыг дээдэлсэн чадварлаг менежменттэй, мэргэжлийн өндөр ур чадвартай, уламжлалт анагаах, сэргээн засах тусламж үйлчилгээний оношилгоо, эмчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанарын өндөр түвшинд үзүүлнэ гэсэн зорилт тавин ажиллаж байна.
Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:***

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

***Байгууллагын дотоод хяналтын талаар:*** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын зөвлөл нь 2023 оны ажлын төлөвлөгөөндөө 5 ажил хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт бүрд удирдамж батлуулж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Отгонтэнгэр рашаан сувилалын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Отгонтэнгэр рашаан сувилалын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 76,349.4 мянган төгрөгөөр буюу 9.2 хувиар *өссөн* байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 152,530.70 | 93,683.70 | (58847.0) |
| Үндсэн хөрөнгө | 324,596.00 | 459,792.40 | 135,196.40 |
| **Нийт хөрөнгө** | 477,126.70 | 553,476.10 | 76,349.40 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 477,126.70 | 553,476.10 | 76,349.40 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | 477,126.70 | 553,476.10 | 76,349.40 |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Бараа материалын эхний үлдэгдэл 152,530.7 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 26,942.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 88,534.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 93,683.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,884.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 1,079.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 156,119.5 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдсэн байна. Тайлант онд 18,500.0 мянган төгрөгийн хөрөнгө актлах шийдвэрээр хасагдаж, жилийн эцэст 668,831.9 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 22,213.0 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 76,349.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 299,538.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 299,538.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 299,538.3 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 299,538.3 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| Хөтөлбөр, арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих** | | | | | |
| **71602** | **Нийгмийн эрүүл мэнд** | | | | |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 299,538.30 | 299,538.30 | | **100%** |
| **НИЙТ** | | 299,538.30 | 299,538.30 | | **100%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 **Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 5,460.0 төгрөгийн орлого төвлөрүүлэн, үйл ажиллагаанд зарцуулсан байна.

**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

2023 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

**3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар**

*/Мянган төгрөг/*

| **№** | **Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга** | **Бараа ажил үйлчилгээний нэр** | **Төлөвлөлт** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|---|---|
| 1 | Шууд гэрээ байгуулах | Түлш халаалт | 16,825.40 | 7,500.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | Шууд гэрээ байгуулах | Байрны түрээс | 33,528.00 | 4,000.00 |
| 3 | Шууд гэрээ байгуулах | Гэрэл цахилгаан | 8,557.30 | 645.61 |
| 4 | Шууд гэрээ байгуулах | Цэвэр, бохир ус | 12,482.10 | 3,379.30 |
| 5 | Шууд худалдан авалт | Хангамж бараа материалын зардал | 29,803.30 | 18,847.25 |
| 6 | Шууд худалдан авалт | Нормативт зардал | 112,477.70 | 90,491.25 |
| 7 | Шууд худалдан авалт | Эд хогшил урсгал засварын зардал | 33,250.00 | 27,371.23 |
| | **ДҮН** | | **246,923.80** | **152,234.64** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Завхан аймгийн Отгонтэнгэр рашаан сувилалын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит" ХХК-ийн аудитор Г.Уранбаяр гүйцэтгэж, хяналтыг "Хаан соёмбо аудит" ХХК-ийн захирал Х.Диймаа анхан шатанд хянаж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд, аудитын менежер Х.Болдбаатар нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Отгонтэнгэр рашаан сувилалын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Хаан соёмбо аудит" ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 456,425.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,252.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,689.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 29 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завхан аймгийн Отгонтэнгэр рашаан сувилалын 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 заалт зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлээгүй байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

**5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй.**

**5.2 Албан шаардлага**

Шилэн дансны системд нэвтрэх нэр нууц үгийг нягтлан бодогч олж аваагүй олж авах боломжгүй төрийн сан болон санхүү хяналт дотоод аудит, сангийн яаманд хүсэлт өгөөд

одоогоор шийдвэрлэж амжаагүй байна. Шилэн дансны системийн холболтыг хийлгэж хуулийн дагуу мэдээллийг байршуулах албан шаардлага хүргүүллээ.

### 5.3 Зөвлөмж хүргүүлээгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА ОГНОО: 2024-02-22

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР ОГНОО: 2024-02-22

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД ОГНОО: 2024-02-22

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР Ц.АЛТАНТУУЛ ОГНОО: 2024-02-22